

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай анхдагч хуулийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэж, тус зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж, Арван зургадугаар зүйлийн 2-т Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг баталгаатай эдэлнэ гэж, 17-д “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.” гэж тус тус заасан.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөл батлагдан хэрэгжсэнээр Монгол Улсын Үндсэн хуулийн тус заалтуудыг хангахад гол үүрэг гүйцэтгэх юм.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.6 дахь заалтын 1-д “Газар, түүний нөөцийг зохистой, үр дүнтэй ашиглах, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод газрын харилцааны орчин бүрдсэн байна.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 4.1.6.5-д “олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 130-д “Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах” гэж тус тус заасныг хэрэгжүүлэхээр тус хуулийн төслийг боловсрууллаа.

Байгалийн баялаг олборлох үйлдвэрлэл нь Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 20-30 орчим хувийг дангаараа хангаж, эдийн засгийн өсөлтийн гол эх сурвалж болж ирсэн төдийгүй эдийн засгийн бусад салбарт томоохон нөлөө үзүүлж байдаг. Байгалийн баялаг олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд түшиглэн, улсын эдийн засгийг бэхжүүлэх, нөгөө талаас уг салбарыг нээлттэй, ил тод, хариуцлагатай байлгаж, татварыг улсын төсөвт зохистой төвшинд төвлөрүүлэх, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор хяналт, дүн шинжилгээ болон тайлагнал зэргийг иж бүрэн, үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага тулгамдаад байна.

Олборлох үйлдвэрлэл нь голдуу зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, гэрээ, эрхийн хүрээнд явагддаг бөгөөд Олон улсын валютын сан, Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага, Дэлхийн банк, Мөнгө угаахтай тэмцэх, санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага зэрэг олон улсын байгууллагууд байгалийн баялаг, ялангуяа ашигт малтмалын нөөц баялаг ихтэй улс орны олборлох үйлдвэрлэлийг эрсдэлтэйд тооцож, авлига, албан тушаал, мөнгө угаах болон бусад санхүүгийн гэмт хэргийн гаралт өндөр гэж үздэг.

Монгол Улс олборлох үйлдвэрлэл дэх ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх ажлыг шат дараалалтай хэрэгжүүлж ирсэн бөгөөд олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, төр болон хувийн хэвшлийг хариуцлагажуулах зорилго бүхий, дэлхийн 52 улс орон нэгдэн орсон “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай санаачилга” /цаашид “ОУИТБС” гэх/-д 2007 онд, Нээлттэй засаглалын түншлэлд 2013 онд тус тус нэгдэж, олборлох үйлдвэрлэлд мэдээллийн ил тод байдлыг ханган хэрэгжүүлэхээр олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө үүрэг амлалтыг авсан. Гэсэн хэдий ч ОУИТБС-ын хүрээнд авсан үүрэг амлалтаа Монгол Улс бүрэн хэрэгжүүлэхэд өнөөгийн эрх зүйн орчныг хангалттай бүрдүүлээгүй байгаа юм.

Тиймээс бие даасан хууль боловсруулан, олборлох үйлдвэрлэлд хамаарах салбарыг тодорхойлох, тэдгээрийн нээлттэй мэдээллийг бүрдүүлсэн мэдээллийн сан бий болгох, олон талт бүлэг болон оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг хуульчлах шаардлагатай.

Хуулийн үйлчлэх хүрээ буюу олборлох үйлдвэрлэлд зөвхөн Ашигт малтмалын тухай хуульд заасан ашигт малтмалаар хязгаарлах бус бусад хуулиар зохицуулдаг ус, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмалыг хамруулахаас гадна байгалийн бусад баялаг болох амьтан, ургамал, ойн баялгийн ашиглалтын үйл ажиллагаанд мөн ил тод байдлыг хангах нийтлэг зохицуулалт бүхий бие даасан хуультай болох нь оновчтой гэж үзэж байна.

Олборлох үйлдвэрлэл дэх төр болон бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах нь тухайн улс орны байгалийн баялгийн нөөцийг хэрхэн удирдаж, ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулж байгаа талаар мэдээ, мэдлэгийг нэмэгдүүлдэг. Энэ нь олборлох үйлдвэрлэл болон түүний зөвшөөрлийг эзэмшиж байгаа этгээд хэн болох, түүнд ямар санхүүгийн нөхцөл хамаарч байгаа, олборлох үйлдвэрлэлд зарцуулсан зардал, олж байгаа орлого, түүний зарцуулалтын зэрэг мэдээлэл рүү илүү төвлөрүүлдэг байна. Эдгээр мэдээллийг ил тод болгох нь байгалийн баялгийн нөөц, хөрөнгө, орлогыг өндөр үр ашигтайгаар ашиглах, зарцуулахад суурь тулгуур болж өгдөг.

Оролцогч этгээдүүдийн хэрэгцээ, шаардлагыг хангасан, цаг үеэ олсон, чанартай мэдээллийн ил тод байдал нь хариуцлагатай байдал болон сайн засаглалыг дэмжиж, төрийн хариуцлагатай, үр дүнтэй байдлыг сайжруулах, улмаар авлигыг бууруулах зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Дээр дурдсан хууль зүйн үндэслэл болон практик шаардлагын дагуу Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулаад байна.

Хуулийн төслийг 4 бүлэгтэйгээр боловсруулсан ба тус бүлгүүдэд доор дурдсан асуудлуудыг тусган боловсруулсан. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хуульд хэрэглэгдэх нэр томъёоны тодорхойлолт, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын зарчим зэргийг тусгалаа.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангаснаар хүрэх зорилгын үндсэн дээр хуулийн төслийн зорилтыг тодорхойлж өглөө.

Дор дурдсан зорилгуудад хүрэхэд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах нь нэг гол алхам болно гэж үзэж хуулийн зорилтыг тодорхойллоо. Үүнд:

1. Байгалийн баялаг ашиглалтыг үндэсний ашиг сонирхолд нийцүүлэх;
2. Эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийг дэмжих;
3. Байгалийн баялгийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх;
4. Олборлох үйлдвэрлэлийг байгальд сөрөг нөлөө багатай, хариуцлагатай эдийн засгийн салбар болгон хөгжүүлэх;
5. Байгалийн баялаг ашиглах үйл ажиллагаанд олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлж, иргэний мэдэх эрхийг хангах;
6. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх зэрэг.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангахад нээлттэй мэдээлэл, мэдээллийн сан, мэдээлэл хүргэх дэд бүтэц, тэдгээрийн хоорондын уялдаа холбоо, нийцлийн зохицуулалт чухал үүрэг гүйцэтгэх тул Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хууль тогтоомжид Монгол Улсын Үндсэн хуулиас гадна Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг тодотгон тусгалаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэж, тус зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж зааснаас үзвэл “байгалийн баялаг”-т зөвхөн эрдэс баялгаас гадна ой, ус, амьтан, ургамал хамаарч, эдгээр баялаг нь ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байхаар байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалтуудыг үндэслэн, мөн эдгээр байгалийн баялгууд нь хоорондоо харилцан шүтэлцээ, хамааралтай, хязгаарлагдмал нөөцтэйгөөс гадна, байгалиас заяасан, аливаа хувь хүн, хуулийн этгээдийн өмчлөлд бус, Монгол Улсын ард түмний мэдэлд байдаг тул

“олборлох үйлдвэрлэл” гэх ойлголтод зөвхөн эрдэс баялгийг хамруулах бус байгалийн бусад баялаг болох ус, амьтан, ургамал, ойн баялгийг хамруулан тэдгээрийн ашиглалтын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зохицуулалт бүхий бие даасан хуультай болох нь оновчтой гэж үзэж хуулийн үйлчлэх хүрээг тодорхойлон тусгалаа.

Олборлох үйлдвэрлэлд хамаарах төр болон хувийн хэвшлийн зарим тодорхой мэдээллийг нээлттэй, ил тод болгож хуульчлахтай холбогдуулан төрийн нууц буюу задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг хамгаалах зорилгоор төрийн нууцыг тус хуулийн үйлчлэлд хамааруулахгүй байхаар мөн тусгалаа.

Хуулийн нэр томъёоны тодорхойлолтод тус хуулийн төсөлд хуулийн үйлчлэх хүрээ, холбогдох үйл ажиллагаатай холбогдон хэрэглэгдсэн гол гол нэр томъёог тусган тодорхойлсон.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын зарчмыг хуулийн зохицуулах харилцаатай уялдуулан, тус харилцаанд гол баримтлах чиглэлүүдийг тодорхойлон тусгасан. Түүнчлэн “олборлох үйлдвэрлэл”-д хамаарах үйл ажиллагааг тусгайлан зарчим хэсэгт тодорхойлж өглөө.

Хоёрдугаар бүлэгт олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах эрх зүйн орчин буюу мэдээллийн сан, мэдээллийн санг бүрдүүлэх нээлттэй мэдээллийн хүрээ, жагсаалт, мэдээллийн сангийн мэдээлэл нийлүүлэгч, мэдээллийн сан хариуцагч этгээд, тэдгээрийн эрх, үүрэг, мэдээллийн санд мэдээлэл оруулах журам, мэдээллийн сан дахь мэдээлэл хадгалалт, хамгаалалтын талаар тусгалаа.

Мэдээллийн сангийн тухайд олборлох үйлдвэрлэлд хамаарах 5 чиглэлийн үйл ажиллагаа тус бүрээр буюу эрдэс баялаг олборлох үйлдвэрлэлийн, үйлдвэрлэлийн зориулалтаар усны нөөц ашиглах, ойн баялаг ашиглах, амьтан агнах, барих, байгалийн ургамлын нөөц ашиглах үйл ажиллагаа тус бүрээр нээлттэй мэдээллийн 5 сантай байхаар, эдгээр мэдээллийн санд тавигдах шаардлага, мэдээллийн санг ашиглах зорилго, мэдээллийн сангуудыг бүрдүүлэх мэдээллийн хүрээ, түүнд хамаарах мэдээллийн жагсаалтыг дэлгэрэнгүй тусгалаа.

Эрдэс баялаг олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагааны мэдээллийн санд дараах 15 хүрээний тодорхой мэдээллээс бүрдүүлэхээр тусгалаа. Үүнд:

- 1.эрдэс баялаг олборлох үйлдвэрлэлтэй холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээ, захиргааны хэм хэмжээний акт;
- 2.зөвшөөрөл, түүний бүртгэлийн мэдээлэл;
- 3.гэрээ, хэлэлцээр, түүний нэмэлт, өөрчлөлт болон хэрэгжилтийн мэдээлэл;
- 4.зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл;
- 5.эрдэс баялаг хайгуулын мэдээлэл;
- 6.эрдэс баялаг олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын мэдээлэл;
- 7.төсвийн болон бусад орлого төвлөрүүлэлтийн мэдээлэл;
- 8.төсвийн орлогын хуваарилалтын мэдээлэл;
- 9.зөвшөөрөл эзэмшигчээс нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн зарцуулалт;

10. уурхайн хаалт, байгаль орчин нөхөн сэргээлтийн мэдээлэл;
11. хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгчийн мэдээлэл;
12. эрдэс баялаг олборлох үйлдвэрлэл эрхэлж байгаа төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдтэй холбоотой мэдээлэл;
13. эрдэс баялаг олборлох үйлдвэрлэлээс төрд ногдох хувь хэмжээг зарж борлуулах, эсхүл бэлэн бус байдлаар олсон бусад орлогын мэдээлэл;
14. эрдэс баялаг олборлох үйлдвэрлэлээс эдийн засагт оруулах хувь нэмрийн талаарх мэдээлэл;
15. эрдэс баялаг олборлох үйлдвэрлэлээс байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл.

Дээрх 15 хүрээнд хамаарах зарим мэдээллийг онцолж дурдахад өмчийн хэлбэрээс үл хамааран зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ, орд ашиглах гэрээ, хөрөнгө оруулалтын гэрээ, нутгийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ, зөвшөөрөл эзэмшигчийн тухайн жилийн олборлосон, баяжуулсан, боловсруулсан эрдэс баялаг, баяжмал, бүтээгдэхүүний төрөл, төрөл тус бүрийн хэмжээ, тухайн жилд борлуулсан эрдэс баялгийн тоо хэмжээ, төрөл, борлуулалтын үнэ, зөвшөөрөл эзэмшигч этгээдийн хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгчийн мэдээлэл, эрдэс баялаг олборлох үйлдвэрлэлийн нийт ажилтны тоонд гадаад ажилтны эзлэх хувь, ажиллах байршил, ажлын байрны нэр, холбогдох зөвшөөрөл, Монгол Улсын иргэдийн хүйс, боловсрол, ажиллаж байгаа хөдөлмөрийн нөхцөл, ажлын байрны нэр, зөвшөөрөл эзэмшигчийн тухайн жилийн хөрөнгө оруулалт, зардлын мэдээлэл зөвшөөрөл эзэмшигчийн эрх бүхий байгууллагаар батлуулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, түүний биелэлтийн тайлан гэх мэт.

Үйлдвэрлэлийн зориулалтаар усны нөөц ашиглах үйл ажиллагааны мэдээллийн санг 16 төрлийн мэдээллээс бүрдүүлэхээр тусгалаа. Тухайлбал, Усны тухай хуулийн 16¹.4.10, 16¹.4.11-д заасан дүгнэлт, ус бохирдуулсны төлбөрийн гэрээ, гэрээний хэрэгжилт, тухайн сав газарт ашигт малтмалын хайгуул хийх, олборлолт явуулах тусгай зөвшөөрөл олгоход харьяалах сав газрын захиргаанаас өгсөн санал, усны нөөцийг хуримтлуулах, ашиглах, уул уурхай эрхлэх болон далан, суваг барих төсөлд Сав газрын зөвлөлөөс өгсөн санал, хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл, зөвшөөрөл авсан этгээдийн жагсаалт, зөвшөөрөлд заасан хаягдал ус зайлуулах хэмжээ, зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон мэдээлэл, зөвшөөрлийн хүчинтэй хугацаа, ус ашиглагчид олгосон цооног өрөмдөх, худаг гаргах, голоос суваг шуудуу татах зөвшөөрлийн мэдээлэл, зөвшөөрөл авсан этгээдийн жагсаалт, зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон мэдээлэл, зөвшөөрлийн хүчинтэй хугацаа, ус ашиглуулах талаар эрх бүхий байгууллагаас гаргасан дүгнэлт, ус ашиглагчийн зөвшөөрөл, зөвшөөрөл авсан этгээдийн жагсаалт, зөвшөөрлийн хүчинтэй хугацаа, олгосон, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл, эрхийн бичиг, гэрээ, хуулийн этгээдийн хэрэгжүүлэх төслийн үргэлжлэх хугацаа, төслийн нэг жилийн усны хэрэгцээ, ус ашиглагчийн ашигласан усны хэмжээ, ус ашигласны төлбөр төлөлтийн байдал гэх мэт.

Ойн баялаг ашиглах үйл ажиллагааны мэдээллийн санг ойн менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт, ойн сан болон түүний хэсгийг эзэмшиж, ашиглаж байгаа этгээдийн жагсаалт, гэрээ, түүний хэрэгжилт, ойн

мэргэжлийн байгууллагын жагсаалт, эрхийн мэдээлэл, гэрээ, түүний хэрэгжилт, тухайн жилд ойгоос бэлтгэх модны батлагдсан хуваарь, түүний хэрэгжилт, ойн нөөц ашигласны төлбөр, хураамжийн ногдуулалт, төвлөрүүлэлтийн мэдээлэл, тухайн жилд ашиглахаар тогтоосон ойн нөөцийн хэмжээ, мод бэлтгэх шийдвэр, гэрээ, бэлтгэх модны дээд хязгаар, түүний хэрэгжилт, тухайн жилд экспортлогдсон Монгол Улсын гарал үүсэлтэй ойн нөөц, мод, модон материал, ойн дагалт баялгийн төрөл, хэмжээ гэх мэт 24 төрлийн мэдээллээс бүрдүүлэхээр тусгалаа.

Амьтан барих, агнах үйл ажиллагааны мэдээллийн санг 25 төрлийн мэдээллээс бүрдүүлэхээр тусгалаа. Онцолбол, ан агнуурын менежментийн төлөвлөгөө, амьтан агнах, барихад олгосон зөвшөөрөл, түүний зориулалт, агнуур зохион байгуулалтын ажил гүйцэтгэх эрх авсан мэргэжлийн байгууллагын жагсаалт, эрхийн талаарх мэдээлэл, аймаг, нийслэлийн тухайн жилд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний тогтоосон дээд хязгаар, тухайн жилд тусгай зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээ, нэн ховор амьтныг амьдаар нь гадаад улсад гаргахад Засгийн газраас олгосон зөвшөөрөл гэх мэт.

Байгалийн ургамлын нөөц ашиглах үйл ажиллагааны мэдээллийн санг нэн ховор ургамлыг судалгаа шинжилгээний зориулалтаар түүж бэлтгэх зөвшөөрөл олголт, ховор, элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх зөвшөөрөл олголт, түүний зориулалт, байгалийн ургамал гадаад улсад гаргах зөвшөөрөл олголт, түүний зориулалт, улсын тэмдэгтийн хураамж төлөлт болон байгалийн нөөц ашигласны төлбөр төлөлтийн мэдээлэл зэрэг 8 төрлийн мэдээллээс бүрдүүлэхээр тусгалаа.

Түүнчлэн мэдээллийн сангуудыг холбогдох асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд тус тус хариуцахаар тусгалаа.

Мэдээллийн санд тухайн мэдээллийг нийлүүлэх этгээдийг Засгийн газраас тогтоох ба мэдээлэл нийлүүлэгчийг мэдүүллийн санд бүртгэх, баталгаажуулах журмыг Үндэсний зөвлөл батлахаар, мэдээлэл нийлүүлэгч, мэдээллийн сан хариуцагч этгээдийн үүргийг тус тус тусгалаа.

Мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн санд хандах, нэвтрэх, нэгдсэн порталд холбох журмыг Засгийн газар батлахаар, мэдээллийн сангийн мэдээлэл нь 16 жилээс доошгүй хугацаанд хадгалагдаж, хуульд өөрөөр заагаагүй бол олон нийтэд ил тод, нээлттэй байхаар, мэдээллийн сан нь татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай холбогдсон байхаар тус тус тусгалаа.

Гуравдугаар бүлэгт Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулах, хяналт тавих, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хэрэгжилтийг Засгийн газарт тайлагнах чиг үүрэг бүхий Үндэсний зөвлөл, түүний салбар зөвлөл, тэдгээрийн чиг үүрэг, бүтэц, бүрэлдэхүүн, Ажлын алба болон олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайлан, түүний төрөл, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилтийн талаар тусгасан бөгөөд мэдээлэл нийлүүлэгч болон төрийн байгууллагын тайлан, мэдээлэлд үндэслэн Үндэсний зөвлөлөөс нэгтгэн гаргах олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн тайлантай холбоотой зохицуулалтыг тусгалаа.

Дөрөвдүгээр бүлэгт олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангахтай холбогдуулан гомдол гаргах, хяналт тавих, маргаан шийдвэрлэх журам, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох зохицуулалтыг тусгалаа.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөл батлагдсанаар тухайн ондоо батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах бөгөөд эрх зүйн орчныг бүрдүүлснээр урт хугацаанд нийгэм, эдийн засагт дараах эерэг үр дүн гарна гэж үзэж байгаа юм. Үүнд:

1/Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын олон улсын дэвшилтэт хандлагад нийцсэн хамтын удирдлага, хамтын хяналтын тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц бий болно.

2/Олборлох үйлдвэрлэл дэх төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн зохистой түншлэлийн хэлбэр бий болно.

3/Олборлох үйлдвэрлэл дэх авлига, ашиг сонирхлын зөрчлийг бууруулах, таслан зогсоох нөхцөл бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

4/Олборлогч компаниуд, төр, олон нийтийн байгууллага хоорондын харилцаа, үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд ил тод болж олон нийтийн зүгээс хяналт тавих боломжтой болно.

5/Олборлогч компаниуд, ялангуяа төрийн өмчит аж ахуйн нэгжийн зардал буурснаар ашигт үйл ажиллагаа нэмэгдэж улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого нэмэгдэнэ.

6/Олборлох үйлдвэрлэлээс төрийн байгууллагад төлсөн татвар, хураамжийн зарцуулалт, хуваарилалт ил тод болсноор баялгийн сан зэрэг баялгийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх сэдлийг үр дүнтэй болгож бэхжүүлнэ.

7/Засгийн газар, компаниудын удирдах болон шийдвэр гаргах эрх бүхий ажилтнуудын хариуцлагатай байдлыг нэмэгдүүлж, салбарын оролцогчдыг тодорхой болгож, олон нийт үнэн зөв мэдээлэл авах боломжийг бүрдүүлнэ.

8/Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах талаас томоохон эерэг нөлөө үзүүлнэ.